



Уран зохиолын онлайн хичээл

“Шинэ Эрин” сургуулийн МХБУЗ-ын
багш Ш. Батцэцэг



Зохиолч С.Эрдэнэ

Сэдэв: “Өвгөн шувуу” өгүүллэгийн
хэл найруулгыг задлан шинжлэх




Суралцахуйн зорилт

01

Зохиолын хэлбэр, бүтэц, хэл найруулгаас суралцан, уран дүрслэл ашиглаж, санаагаа төгсгөн зохиож бичих

02

Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэг лүүрээс суралцан, уран сайхан илтгэх



Та нарын бодлоор бол...



1. Орчлонгийн жам ёсны тухай ойлголт - "Төрөх үнэн үхэх үнэн"

2. Найз нөхөрлөлийн тухай ойлголтын талаарх та нарын үзэл бодол юу вэ?

Зохиолын эхлэл хэсэг

Өгүүллэгийн гол дүр Жав өвгөнийг дүрслэхдээ:

Зовхи нь хөх няц болон хавагнаж, ухархайдаа(нүдний хонхорхой) хон хойн ширгэсэн гэрэлгүй нүд...

Хянган хамрын(хамрын овгор хэсэг) самсааны(хамрын 2 хажуугийн хон хор) мөгөөрс(хатуу бүрхүүл) нэвт гэрэлтэн шанааны нь яс арьсаа цоо татах бий гэмээр ёрдойжээ.

Яс арьс болсон гараараа орны хөлөөс уясан татуурганаас чангааж..

1. Яс арьс болсон гэсэн хэлц үгийн утгыг тайлбарлана уу? Ямар учраас өвгөн ийм байдалтай байна вэ? Учир шалтгааныг дүрийн дүрслэлээс тодруулан тайлбарлана уу.

2. Дүрийн гадаад дүр төрхийг дүрс лэхдээ ямар, ямар үг хэрэглэсэн байна вэ?



- Царайны нь өнгө энэ нүгэлт ертөнцөд амьдрах өдөр тоотой хүн гэдгийг илтгэнэ
- Жав гуай тэнгэрийг тооноор, газрыг үүдээр харах төдий болсоор уджээ

Нүгэлт ертөнц - ?

- ✓ Жаран хэдэн жил амьдарсан хорвоо ертөнц
- ✓ хүний насан хязгаартай ямархан жам тай ертөнц билээ

1. Зохиолч яагаад “нүгэлт ертөнц” гэсэн үгийг сонгож хэрэглэсэн юм бол.. Та нар юу гэж бодож байна вэ?
2. Амьдрах өдөр тоотой хүн гэсэн учрыг зохиолын жишээгээр тайлан тайлбарлаарай

Жишээлбэл: нүгэлт ертөнц – гэвч салмааргүй ертөнц

Хүний амьдралын жам ёс

- Жав энэ ертөнцөд хүн болж төрөөд юу эсийг үзэх вэ дээ
- Насаараа хөндлөн гулд давхисан тал нутаг, үзэж өнгөрүүлсэн амьдрал нь үүрд нүдээ анихаас нааш яаж балран арилах билээ.
- Эцэст нь хорвоогийн жам ёсоор цагийн эрхээр, хүндээр өвчилсөн учир хэвтэрт удаж, 1 жилийн нүүр үзсэн...
- Цаг нь болохоор энэ ертөнцөө орхин одно



Үхэхийн тухай бодож яваагүй боловч үхэхээс нэг их айхгүй хүн байж. Зоригтой тайвнаар үхлээ хүлээж байна. Сэтгэлээр машид хатуу жин чадахад биеийн шаналал хүртэл намдаад явчихна.


Жав өвгөний зан чанар, бодол, үг яриа, үйлдлийн дүрслэлээс санаа авч, дүрийг дүгнээрэй. Өвгөний биеийн зовуурь, сэтгэлийн тэнхээ болон дүрийн дотоод сэтгэл зүйг зохиолын жишээгээр батлан тайл барла.

Жав өвгөний хэлсэн гомдол алга гэсэн үгийн учир юу вэ?


Жав өвгөний туулж өнгөрүүлсэн амьдралын утга учир юунд оршиж байна вэ?

ХЭЛЦ

- «Одоо ингээд (өвчин)зовлон дуу сах цаг ирээгүй» юу гэж горьдох боловч өдөр хоног өнгөрсөөр л байна. Хүн гэдэг мөн ч **бөх голтой** юм. **Утсан чинээхэн улаан амь** гэвч тасарч өгөх гүй нь гайхалтай.
- Жав гуай өнгөрсөн хаврын цагаан хагднаар **хадан гэртээ харина** гэж бодож байсан боловч бүтсэнгүй. «Би ер нь **долоон голтой** амьтан юм аа» гэж хвнд ярина.



**Хэлц үгийг олж,
утгыг тайлбарлая**



.... Өвчин нь ч нэгэнт газар авч нөгөө **утсан чинээ улаан гол** л аргагүй нэг цохиж байгаа нь илэрхий болжээ. **Үхэх өдрөө хүлээнэ гэдэг өнгөрснөө бодож хэвт гэсэн үг** байж. Жав гуай голтой байгаагийн ганцхан учир утга л түүнд байна. Бусдаар бол хүний тооноос аль хэдийн өөрийгөө хасжээ. **Бие үхэхээс урьтаж ухаан үхчих вий гэдэг л ганц айх юм нь. Гэвч бие доройтох тусам ухаан улам саруул болж байлаа.**

Өнгөрүүлсэн амьдралаа бодож эргэцүүлэх боломж олгох хугацаа ч юм уу

Ухаанаа урьтаж үхэх вий гэдгээс болгоомжилно...

1

Монгол өвгөдийн их ухаан, уламжлал тусгагдсаныг бодит амьдралын жишээтэй холбон тайлбарлаарай. **Үхэхээс айхгүй байгаа. Гэвч эсрэгээрээ ухаан үхэхээс айна.**

Өнгөрүүлсэн амьдралаа
хэрхэн яаж дурсан санаж
байгааг зохиолын жишээ
гээр тайлан тайлбарлаа
рай.



- Өнөө өглөө өвдөх шаналах юм нь нэгэнт дууссан мэт хачин байх ажээ.
- Нутгийн өвгөцүүлийг дуудуулахад аргагүй цаг нь тулаад амин дээрээ байлгахыг бодож дээ гэж үеийн 3 өвгөн яаран ирлээ. (нөхөрлөлийн үнэ цэн)
- ...хүрэн торгон дээл өмсөж, 1945 оны дайнд түр цэрэгт татагдан яваад авсан шар гуулин медалиа зүүчхээд...

“

«Боргоцой чи тэр жил намайг яаж чадсанаа яриач» гэв. Боргоцой Дорлиг бугуйн даа алтан цаг зүүж, нүдэндээ сүүдэр шил зүүчихсэн дэгжин шовгор өвгөн ярих аасаа түрүүн хээг хээг инээгээд, Би багийн дарга, Жав ухуулагч тэр зун алба ширүүнийг хэлэх үү. Дайны урьд жил шүү дээ. Залуу ч байж. Цэргийн агт, ноосны ноогдол гүйцээх гээд л бид хоёр өдөр шөнөгвй айл хэсдэг байлаа. Нэг өдөр доод Хүрэмт орж явсан чинь зам дээр морио барьсан хүн хэвтэж байна. Хүрээд очтол мань хүн хурхирч хэвтдэг байгаа. Тэгэхээр нь шогломоор санагдаад морийг нь хөтлөөд алга болж өглөө. Мөн ч дүрсгвй байж дээ. Мань хүн нэг сэрэхнээ явгар чихсан байдаг. Энэ мэтээр идэр залуугийнхаа элдэв явдлыг дурсалцана.

”



Үе тэнгийн 3 өвгөн-Жав өвгөн, түүний найзуудын нөхөрлөл


- ✓ Гэээгт Найдан – багын түнш, гэээгтэй, хүдэр хар өвгөн, нутгийн их хүндтэй хүн (хуйв-уурганы оосроо Жав өгсөн)
- ✓ Боргоцой Дорлиг - олон жил хамтдаа баг сумын алба хааж явсан, бугуйндаа алтан цаг зүүж, нүдэндээ сүүдэр шил зүүчихсэн дэгжин шовгор өвгөн...(Дорлиг ганган учир Жав хөөргөө өгсөн)
- ✓ Үеэл шумуул Жамц – гонгиносон нарий хан дуутай өвгөн
- ✓ Дэвхрэг Жав
- ✓ Нэг голын, нэг үеийн өвгөцүүл урт амьд

рал туулж, насан хэвийхийн жам ёсоор уван цуван цөөрсөөр боловч нэг нь ингэж тасраад талийчихна гэдэг амьдрал өм цөм үсэрнэ гэсэн үг.

Өвгөдийн дүрийг хооронд нь харьцуулна уу.

Жав гуай тэдэнд Муу Дэвхэргийн чинь амьд явах хоног аргагвй гүйцэж байна. Та нарыгаа нэг хараад үхье гэж шийдлээ. Үхэхийн өмнө нэг сайн наргиж, та нарынхаа дуулах хуурдахыг сонсьё. Урьдын цагт юмсан бол хойт насандаа уулзаж юу магад гэх сэн. Намайг та нар эс мэдэх биш. **Үхэлгвй мөнх хорвоо дээр төрсөн бол** одоо яая гэхэв.

Муу дэвхэргээ алсын замд үдэж байна гэж бодоод л ууцгаа! Заавал хөдөөлvvлж ирчихээд уй гашуу тайлж байна гэж уух алба уу? **Ямар ч гэсэн ухаантай амьсгаатай байгаа дээр нь амьд Жавтайгаа урьдын шигээ наргиж байна гэж бодоод** ууцгаа! гэж шахаж байв.



01

Аргагүй хатуу эр гэдгийг мэднэ.

02

Шумуул Жамц чи **хэзээнээс чулуу шиг хатуу сэтгэлтэй** хvн гэснээс санаа авч, Жав өвгөний дүрийн зан чанарыг дүгнэн хэлэлцээрэй

Зохиолын төгсгөл



- ✓ Нутгийн хөх ногоон гүвээ толгод униар дунд замхран үзэгдэх нь уужим боловч хүний насан хязгаартай ямархан жамтай ертөнц билээ гэмээр. Энэ нар, салхи, тэнгэр, гүвээ толгодоо сүүлчийн удаа харж байна гэж Жав гуай бодож байлаа

Найз нөхдөө, нутаг усаа, адуу малаа сүүлийн удаа харж авлаа. Сайн ханьтай, голомт залгах хүүтэй, сайхан нөхөд тэй жаргаж явлаа.

- ✓ Хэчнээн сайхан салж болмооргүй ертөнц боловч Гэээгтийн дуулдаг өвгөн шувуу буцах цаг болжээ. Жаран хэдэн жил дэлхийн тоос хөдөлгөж их юм үзлээ. Гомдол алга. Ийм тийм юм дутуу дунд байсан гэж гажрах юм алга. Ол ны дунд л явлаа.
- ✓ Бид чинь ингээд л уван цуван хойт энгэртээ гарах улс шүү дээ, Жам юм хойно. Ямар манай монголын удам тасрахаар биш! Та нар минь тэгээд үр ач өнөр өтгөн жарган дэгжиж яваарай. Жамц өвгөн сүүлийн үгээ хэлсэн нь түүний хувьд ерөөлийн үг байсан юм.
- ✓ Жав гуай үүр шөнө хагацахын алдад насан өөд болжээ.

Зохиолын үг хэллэг




Хэлц үг – уруу татах, хуучин бууны хугархай, хадан гэр, 7 голтой амьтан, утсан чинээ улаан амь, хүний тооноос хасах, нүд хальтирмаар, тэнгэрийг тооноор, газрыг үүдээр харах

Үхэх гэсэн үгийг хадан гэртээ харих, амьсгаа хураах, амьд явах хоногийн тоо гүйцэх өвгөн шувуу буцах болжээ, хойд энгэртээ гарах гэх мэт хэлц үгсийн утгаар илэрхийлсэн

Зохиолын зохиомж

- Өөрөө өөрийнхөө явдлын тухай өөртөө ярих ярианы нэг хэлбэр. Дүрийн **дотоод яриа** юм. Зохиолын баатар тайван амгалан тунгаан бодох, харамсах, уйтгарлах, санагалзах, бодлогошрох зэрэг дүрийн сэтгэл хөдлөлийг илэрхийлнэ.
- эхийн хэрэг явдлын өрнөлийг эрчимжүүлж, ахиулах ур маягаар дүрсэлж зохиомжилсон.



Дүрслэх хэрэглүүр



- Жав гуай үүдний баруун хатавчинд өлгөсөн хазаар ногт хураалттай бараан дээр гөлмийг нь дэлгэж тавьсан эмээлээ харав. Эзэн нь мордох чадалтай юм шиг эмээл хазаар зэхээстэй байг гэсэн шиг хөгшин нь түүнийг ер хөдөлгөдөггүй билээ.
- Хоймрын авдар дээр хөгшний бадраасан зул гал дохиуртай хар цэцэг мэт бадамлан бөхөж байна. Цаад зун сүмбэр хээ тавьж будсан унь нь нарны гэрэлд ярайна. «Манай гэрийн мод сайн. Хүү халагдаж ирээд бүрээсийг нь шинэчилнэ биз.»Зүүн хаяанд хөгшний орны толгойд улаан шунхан дэвсгэр дээр алтан хорол тавьсан нүүр тэй хуучин цагийн намхан авдар байна. «Түүнийг сэргээгээд буд чихдаг байж дээ. Хөгшин бид хоёрын анхны юм» гэж бодов. Тэр хуучин авдарнаас бусад юм цөм ёсоороо, бөхөж байгаа зул хүртэл ёсоороо бөхөж байх шиг санагдана.

Голомт залгах хүүдээ гэр, адуу мал, авдар-эд хогшил, эмээл зэргийг бэлтгэж, өвлүүлэн үлдээдэг ёс заншлыг тусгасан.

Эд юмсын
дүрслэл
– дүрийг
тодруулах
үүрэгтэй

“

“Өвгөн шувуу” өгүүллэгийн эдэлж өнгөрөөсөн амьдрал, сайхан эх орон, сайн хань, голомт залгах хүү, сайхан нөхөдтэй жаргаж явснаараа бахархаж, үлдэх амьдралаа хайрлаж буй Жав өвгөний дүр сэтгэлийн баялгаараа өвөрмөц юм. Жав бол хар амиа бодох атгаг муу сэтгэлгүй хүн. Ийм ч учраас түүнд хагацаж саламгүй сайхан амьдрал, сайн хань нөхөд заяажээ. Хүний сэтгэлийн баялаг сайхныг харуулсан энэ зохиол хүнд үхэж хагацах ын жамыг бус хүн шиг зөв амьдарч жаргах сэтгэл төрүүлэхээр болсон нь монгол занг харуулах гэсэн зохиогчийн бодол эрмэлзэл хэрэгжсэнийг харуулж байна. (С. Жачин, Уран чадварын увдис, УБ, 2013, 144-р тал)

”



Судлал шүүмж

Зохиолын дүгнэлт



- Өгүүллэгийн гол дүр Жав өвгөний амьдралаас хорвоогийн жам ёс, хүний амьдралын зовлон жаргал, баяр гунигийг дүрслэн харуулсан онцлогтой зохиол юм. Жав өвгөнөөр төлөөлүүлэн, хүний амьдралын утга учрыг өгүүлж, хийж бүтээсэн зүйлтэй байх, бусдад үнэ лэгдэх, үнэ цэнтэй амьдрах
- Холч ухаантай, тэвчээр хатуужилтай, гүдэс шулуун зантай, уужуу тайван, хөгжөөн наргиантай жинхэнэ монгол өвгөний зан төрх, дүр байдлыг дүрслэн үзүүлсэн.
- Өнгөрүүлсэн амьдралаа бодох, дурсамж
- Хүний амьдрал эцэст нь яг л зул бөхөж буй мэт төгсдөг жамтай, хүний амьдрах хугацаа хязгаартай
- Салмааргүй ертөнц боловч буцдаг жамтай
- Монгол хүний зан заншил, сэтгэл зүйн өвөрмөц онцлог, зан төрхийг гаргасан.



**“Өвгөн шувуу хоёр”-ардын
дууг сонсож, зохиолыг “Өвгөн
шувуу” гэж нэрлэсний учрыг
тайлан тайлбарлана уу**

**Дууны агуулга, утга санаа,
сургамжийг зохиолын
санаатай холбон харьцуулж,
өөрсдийн санал бодлоо
илэрхийлнэ үү.**



даалгавар



Анхаарлаа хандуулсанд баярлалаа

Эрсдэлээс өөрсдийгөө сэргийлж, эрүүл мэндээ хамгаалцгаая!

Бүтэцтэй, амттай, үнэ өндөр

